



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/161

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 17-ний 33 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1 нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зарлаж, төслийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Баярмаа)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

2326310322

D:\disk\bichig hereg/ zahiramj/



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ,
ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Газрын хэмжээ (га)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа (жил)
1	4995360	Саарал морьт	0.1	Мал аж ахуйн үйлдвэрлэл	15
Дүн					